


Орхон аймгийн Жаргалант сумын намын хорооны
2020 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн
04 дугаар тогтоолын хавсралт



**ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Монгол хүн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, эрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан АРДЧИЛСАН НАМ 2020 оны Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд **“ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО”** мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.



НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- Ерөнхий боловсролын сургуулийн сурах орчин нөхцлийг сайжруулж, дотуур байранд амьдрах малчдын хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.
- Боловсролын салбарт “Ногоон хөгжил, ногоон ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбайн аюулгүй орчинг бүрдүүлж, сурах нөхцөл боломжоор хангана.
- Хүүхэд хамгааллын асуудалд анхаарч, хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийг бууруулах, багш, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг дэмжин, хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй сургалтын орчин бүрдүүлнэ.
- Олон нийтийн номын сан байгуулна.
- Сумын нийгмийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.
- Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах нөхцлийг бүрдүүлнэ.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- ХАА-н бааз суурьтай фермерүүдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин, малжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжинэ.
- Сумын ерөнхий төлөвлөгөөнд газар олгох, эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар оновчтой, үр дүнтэй, хүртээмжтэй бодлого баримтална.
- Аялал жуулчлалын бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийг тогтвортой, хүртээмжтэйгээр хүргэж, байнгын болон түр ажлын байрыг бий болгоно.
- Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг сэргээнэ.

ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- Авто замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд дугуйн болон явган замыг давхар шийддэг болгоно.
- Биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- “Жорлонгоо өөрчилъе” төслийг эхлүүлэх, Хот-Иргэн хоёрын хамтын механизм хөгжүүлэн, гэр хорооллын айл өрхийн жорлонг шинэчилж, жорлонгоос үүдэх өвчлөл, бохирдолыг бууруулна.
- Ногоон хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд мод тарих, ойн сан хамгаалах, усан сан, парк байгуулах, ойн төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах иргэдийн бүлэг, нөхөрлөлийг бодлогоор болон урамшуулал хөнгөлөлтийн олон талт хэлбэрээр дэмжинэ.
- Өвлийн спорт, амралтын цогцолборыг хувийн хэвшлийн дэмжлэг, оролцоотойгоор байгуулна.



ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- Сумын хурал, төр захиргааны байгууллагад “Нийтийн сонсгол”-ын хуулийг мөрдүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, хэвшүүлнэ.
- Сумын гудамж талбайн тохижилтыг иргэд айл, өрхийн оролцоотойгоор шийддэг хэлбэрт шилжүүлнэ.
- Бүх шатны төрийн байгууллага, төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд шилэн данс, цахим тендерийг жигд хэрэгжүүлж, хэвшүүлнэ.
- Томоохон зах, үйлчилгээний төвд төмс, хүнсний ногоо борлуулах худалдаа, үйлчилгээний цэгийг хувийн хэвшлийн дэмжлэг, оролцоотойгоор байгуулахыг дэмжинэ.
- Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлэх асуудалд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч, тусгадаг болно.
- Сумын сууц өмчлөгчдийн холбоог бүтэц зохион байгуулалтын шинэ хэлбэрт шилжүүлж, менежментийг нь оновчтой болгох ажлыг иргэдийн санал санаачилгад тулгуурлаж хэрэгжүүлнэ.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

- “Цэвэрч-Найрсаг” Жаргалант сум хөдөлгөөн өрнүүлж бүх нийтийн үйлс болгоно.
- Гэр хорооллын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Гэр хорооллын оршин суугчдын түлшний хэрэглээг аюулгүй болгох, агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгах, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолыг эрс багасгана.
- Гудамж, талбайг иргэдийн оролцоотой тохижуулж, гудамж хоорондын замыг шинэчлэн сайжруулна.
- Хорооллын айлуудыг цэвэр усны найдвартай эх үүсвэрт холбох ажлыг сэргээнэ.
- Сумын гудамж талбай, сургууль, цэцэрлэгийн орчны камержуулалтыг нэмэгдүүлнэ.
- Байгалийн давагдашгүй хүчин зүйл, болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдлийг даван туулах чадавхийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Амины орон сууцны инженерийн шугам сүлжээг шат дараатай шийдэх замаар хувийн тохилог орон сууц, байр барих боломжыг нэмэгдүүлэх
- Айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

